

7

БИЗНЕСИЙН САЛБАРУУДЫН САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗАРИМ ШИНЖИЛГЭЭ ДҮГНЭЛТ

Б.Сайнжаргал, Л.Наранчимэг, Л.Оюуншэцэг

Нэг. Санхүүгийн тогтвортой байдлын агуулга, арга зүйн асуудал

Байгууллагын бизнесийн үйл ажиллагаа хувьсан өөрчлөгдөж, хөгжихийн хирээр нягтлан бодогчдын уламжлалт үүрэг болох хөрөнгө санг барих, хяналт тавих явдлыг голчилсон, өөрөөр хэлбэл “бүртгэх тэмдэглэх” үүрэг нь аж ахуй эрхлэлтийн өнөөгийн нөхцөлд зохицсон удирдлагын үйл ажиллагааны шинэ хандлага болох байгууллагын өнгөрсөн ба өнөөгийн төдийгүй ирээдүйд чиглэсэн, санхүүгийн бодлого зорилтыг зөв тодорхойлж, тэр зорилтоо хэрэгжүүлэх алхамтай нягт уялдах болсоноор тэдний ажил үүрэг нь зөвхөн бүртгэл хөтөлж, олон улсын стандартад нийцүүлэн санхүүгийн тайланг гаргах, хөрөнгө, санхүүгийн нөөцийг зохицуулах гэхчилэн зөвхөн цаг үеийн шуурхай зохицуулалтын хүрээнээс хальж илүү стратегийн шинжтэй болж байна. Энэ нөхцөл байдалтай уялдан бодлогын шийдвэр гаргах, стратеги зорилтыг тодорхойлоход аль болох тус дөхөм болохуйц удирдлагын бүртгэлийн мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх шаардлага тавигдах боллоо. Энэ тогтолцоонд нягтлан бодогч нь “мэдээллийн системийн зохион бүтээгч”-ийн үүргийг гүйцэтгэх ёстой. Тухайлбал: санхүүгийн гүйцэтгэлийн болон урьдчилсан шинжилгээ хийх, санхүүгийн төсөв төлөвлөгөө зохиох, үйл ажиллагааны үр дүнг урьдчилан төсөвлөж тооцоолоход нягтлан бодох бүртгэлийн тоо мэдээг чадмаг ашиглах ур чадварыг эзэмшсэн байх нь нягтлан бодогчийн нэг чухал шинж, тэдний мэргэжлийн ур чадварын хэмжүүр болж байна.

Ерөнхий нягтлан бодогчийн ажил үүргийн хүрээг данс бүртгэл, тооцооны уламжлалт үүргээс удирдлагын дунд түвшинд баримтлах санхүүгийн бодлого шийдвэрийг боловсруулах хүрээнд шилжүүлж ойлгох

хэрэгцээ, шаардлага энд хөндөгдөж байна. Нягтлан бодох бүртгэлийн үндэсний хууль эрх зүйн актуудад ерөнхий нягтлан бодогчийн ажил үүргийн хүрээнд байгууллагын тогтвортой үйл ажиллагааг хангахын тулд санхүүгийн нөөцийг зөв байршуулах, хөрөнгө нөөцийг өсгөн арвижуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэйг заах болсон нь санамсаргүй хэрэг биш юм.

Сүүлийн үед аливаа байгууллагын үндсэн шинж чанарыг тодорхойлох болон бизнесийн түншүүдийг сонгохдоо тодорхой чиг зорилготой байхаас гадна тогтвортой байдлыг нэн түрүүнд чухалчилдаг болсон нь ажиглагдаж байна. Тогтвортой байдлын мөн чанарыг түгээмэл утгаар нь тодорхой чиг зорилготой байх, дотоод нөөц боломж болон хүрээлэн буй орчны хүчин зүйлүүдийн тэнцвэрийг зөв тогтоохын төлөөх байнгын тэмцэл гэсэн байр сууринаас аж ахуйн системийн тодорхойлолтыг гаргах нь түлхүүр асуудал гэж болно. Үйлдвэрийн газрын тогтвортой үйл ажиллагааг хангах нь өнөө үед улам ч хурцаар тавигдаж байна. Үүний шалтгаан нь:

1. Гадаад орчны тогтворгүй сөрөг нөлөөлөл, нөхцөл байдалд зохицсон байгууллагын (үйлдвэрийн газруудын) хэвийн жигд, тогтвортой, үйл ажиллагааг хангах явдал тэргүүн зэргийн зорилт болж байна.
2. Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны тогтворгүй байдал нь гаднаас хөрөнгө оруулах боломжийг хүлээлгэнд оруулж, бизнесийн үйл ажиллагааг сааруулагч болж хувирна.

Тогтвортой байдал буюу тогтворжилт нь хэм хэмжээний зохих хил заагт гадаад орчны нөлөөлөл болон, дотоод өөрчлөлтөөс үл хамааран оршин тогтнох буюу, үйл ажиллагааны зохих тогтворжилтыг бий болгож чадах системийн чадвар юм. Хэм хэмжээ гэсэн ойлголт нь тухайн нөхцөл байдал (хил зааг)-д нийцсэн боломжит утгыг хадгалах буюу системийн тоон шинж чанарыг илэрхийлдэг. Систем нь цаг хугацааны тодорхой заагт үйлчлэх бөгөөд, өөрчлөгдөх тэр цаг хугацаа нь болмогц тогтворжуулагч чанараа алдсаар бизнесийн үйл ажиллагааг сааруулагч болж хувирдаг.

Тогтвортой байдал гэдгийг “хатуу зогсох, шантрахгүй тэмцэх” гэсэн утгын зэрэгцээгээр бас “тогтвортой тэнцвэр”, “өөрчлөлтийн үр нөлөөнд үл автах” гэсэн утгаар ойлгох бөгөөд, нөгөө талаас тогтвортой байдал бол өөрийн анхны байдлаа сэргээн хадгалах чадвар гэсэн санааг илэрхийлдэг. Тогтвортой байдал нь үйл ажиллагааны болон санхүүгийн гэж ангилагдах бөгөөд байгууллагын бүтээгдэхүүн үйлчилгээ, төлбөрийн чадвар, эх үүсвэрийн тэнцвэрт байдал, хөрөнгө капиталын ашиглалт болон өгөөжийг багтаасан нийлмэл ойлголт гэж болно. Санхүүгийн тогтворжилт гэдгийг явцуу утгаар нь гарч болох эрсдлийн хэвийн нөхцөлд бизнесийн ашиг болон өмчөө өсгөн арвижуулах зорилтыг хангахад зохицон нийцсэн төлбөрийн чадварын баталгаажсан, хөрөнгө нөөцийн зохистой хэмжээ гэж

тодорхойлсон байдаг. (Ю.В. Васильев, Л.И. Ушвицкий Комплексный экономический анализ хозяйственной деятельности 508")

Төлбөрийн чадварыг бодвол санхүүгийн тогтвортой байдал нь хөрөнгө эх үүсвэрүүдийн хэмжээ болон тэдгээрийн тэнцвэрт харьцааг харуулдагаараа ялгаатай юм. Тогтвортой байдал гэдгийг орчин үеийн эдийн засгийн ухаанд дараах хоёр үндсэн утгаар хэмжин тооцоолох боллоо.

1. Макро түвшний тогтвортой байдал (эдийн засгийн өсөлтийн тогтворжилт)
2. Микро түвшний буюу аж ахуйн нэгж байгууллагын оршин тогтнох санхүү төлбөрийн чадвар, хөрөнгө эх үүсвэрийн тэнцвэрт байдлыг илэрхийлэх хэмжүүр юм.

Холбогдох ном бүтээл болон судалгаанаас үзвэл эдийн засгийн тогтвортой байдал гэдгийг “зах зээлийн хэвийн орчин нөхцөлд макро эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, харин микро түвшинд өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар бизнесийн хэвийн ашигтай үйл ажиллагааг хангах явдал” гэж болох юм. Манай орны эдийн засаг, бизнесийн салбарын онцлогт уялдуулан авч үзвэл эдийн засгийн тогтвортой байдал гэдэг нь эдийн засаг, санхүүгийн нөөц боломжоо зохистой ашиглах замаар үйлдвэрлэл-үйлчилгээний чанарын өсөлт, арилжааны болон үйлдвэрлэлийн ашигт ажиллагааг хангах, энэ зорилгоор оруулсан хөрөнгийг зохистой ашиглах, санхүүгийн сахилга хариуцлагыг бэхжүүлэх, үйлдвэрлэлийн хүч чадлыг нийгмийн хөгжилтэй уялдуулан хангах явдал мөн. Өөрөөр хэлбэл салбарын эдийн засгийн тогтвортой байдлыг хангахын тулд стратеги зорилгоо хэрэгжүүлэхэд шаардлагатай хүчин чадал, зохих нөөцийг бүрдүүлэн, түүнийг зүй зохистой ашиглах явдал юм. үүний тулд:

- Улс орны нийгэм, эдийн загийн болон байгууллагын зорилго, зорилгоо оновчтой тодорхойлох
- Байгууллагын өөрийн болон гаднаас татан төвлөрүүлсэн хөрөнгө, санхүүжилтыг дээд зэргийн үр өгөөжтэй ашиглах
- Салбарын үйлдвэрлэл үйлчилгээг тасралтгүй нэмэгдүүлэх болон хамт олны нийгмийн хөгжилд хүрэлцэхүйц ашиг хуримтлалыг бүрдүүлэх
- Эдийн засгийн өсөлт, эрэлт хэрэгцээнд уялдуулан, салбарын бүтээх хүч чадлыг нэмэгдүүлэх
- Салбарын техник, технологи, өрсөлдөх чадвар, үйлчилгээний чанарыг сайжруулан, өртөг зардлыг хямдруулах
- Эрх зүйн зохицуулалтанд нийцсэн уян хатан, шуурхай хөшүүрэг, удирдлагын арга механизмыг боловсронгуй болгох явдал гэж тодорхойлж болно.

Аж ахуйн нэгж байгууллагын санхүү бол өртөг бүтээх бодит харилцаа, түүнийг зохион байгуулж үр дүнд хүрэх арга, хэлбэрийн цогц

юм. Аж ахуйн нэгж байгууллагын түвшинд бүтээгдэхүүн үйлдвэрлэгдэн, санхүүгийн андагч хуваарилалт хийгддэг учраас тэр нь улс орны болон эдийн засгийн салбаруудын санхүүгийн тогтворжилтын суурь үндэс болдог. Зах зээлийн бас нэг шаардлага бол аж ахуйн нэгжүүд нь үйлдвэрлэлийн хүчин чадал, борлуулалтын (орлогын) өсөлт төдийгүй, санхүүгийн удирдлагын түвшингээрээ тухайн салбар, бүс нутаг орчин нөхцөлдөө тохирсон, оновчтой хэмжээнд хүрч хөгжих, гадаад болон дотоод хүчин зүйлийн эрсдэл, өрсөлдөгчийн хариу үйлдлийг даах чадвартай, санхүүгийн хувьд харьцангуй бие дааж тогтвортой ажиллах шаардлага тавигдаж байна.

Гэтэл манай бизнесийн нэгжүүд нь хэмжээний хувьд хэт жижиг (80 гаруй хувь нь), тэр бүр төрөлжиж хоршоогүй, өөрийгөө санхүүжүүлэх чадвар султай, хөрөнгийн зах зээлээс санхүүжилт авах боломж нэн хязгаарлагдмал, санхүүжилтын гадаад эх үүсвэрийн олдоц бага, тэгээд ч капиталын (санхүүжилтын) зардал өндөр байгаа, бизнесийн эрх зүйн орчин хараахан төлөвшөөгүй, инфляцийн сөрөг нөлөөлөл гээд олон хүчин зүйлээс хамааралтайгаар бизнесийн удирдлагын орчин үеийн арга хэлбэрүүд ААНБ-ын хэмжээнд тэр бүр нэвтэрч үр дүнгээ өгөхгүй байна.

ААНБ-ын 2006 оны тооллогоор 32.4 мянган бие даасан нэгж тоологдсоны 82.3 хувь (26.7 мянга) нь бизнесийн нэгжүүд бөгөөд тэдгээрийн олонхи (62.7 хувь) нь Улаанбаатар хотод төвлөрсөн, зохион байгуулалтын хэлбэрийн хувьд нөхөрлөл хоршоо (14.1 хувь) болон хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК – 66.4 хувь) зонхилсон, хэмжээний хувьд ажиллагчдын тоогоор 80.9 хувь, борлуулалтын орлогоор 90.1 хувь нь жижиг нэгжүүд байгаа бөгөөд тэдгээрийн бараг 1/4 буюу 6.2 мянган нэгж нь үйл ажиллагаагаа хэвийн явуулж чадахгүй байгаа, суурилагдсан хүчин чадлын ашиглалт дунджаар 76.9 хувь, дутуу ашиглалт болон үйл ажиллагаа зогссон шалтгааны 27.5-37.5 хувь санхүүгийн бэрхшээлээс хамаарч байгаа дүн гарчээ. Энэ тооллогоос хойшхи 2 жилийн хугацаанд эдийн засаг, бизнесийн орчны харьцангуй эерэг нөлөөлөл давамгайлсан боловч 2008 оноос хоол хүнсний хомсдол, нефть бүтээгдэхүүний үнийн өсөлттэй холбоотойгоор нөхцөл байдал эсрэгээр өөрчлөгдөн хүндрэлүүд үүсэж эхэллээ. Дээрх тоо баримт болон судалгаанаас харахад манай аж ахуйн нэгжүүдийн 84 хувь нь жижиг аж ахуйнууд бөгөөд салбарын зохистой бүтэц хараахан төлөвшиж чадаагүй худалдаа үйлчилгээний нэгж зонхилсоны зэрэгцээ аж ахуйн нэгж байгууллагын суурилагдсан хүчин чадал, борлуулалтын орлого бага, импорттой өрсөлдөх чадвар сул байгаагаас тэдгээрийн үйл ажиллагаа болон санхүүгийн байдал тогтворгүй, өөрийн эдийн засгийн өсөлтийг хангах үндсэн эх үүсвэр болох ашиг хуримтлал нь тэр бүр нэмэгдэхгүй байна.

Судлаачид санхүү-эдийн засгийн үзүүлэлтүүдийн нормативт утгын хадгалагдах хугацааг харгалзан статик болон динамик тогтвортой байдлыг авч үзэх саналыг дэвшүүлэх боллоо. Статик загварыг дэмжигчид

тогтвортой байдлыг хөрөнгө санхүүгийн нөөцийн хүрээнд тавьж байгаа бол, динамик хувилбарыг дэмжигчид оруулсан хөрөнгийн ашиглалтын үр дүнг илүүд үзэж байна. Үр дүнг тодорхойлохдоо өргөн ба явцуу хоёр утгаар авч үзэж болох бөгөөд үр дүнг үйлдвэрлэлийн, хөрөнгө оруулалтын, санхүүгийн гэж ангилдаг. Динамик загварын хувьд ААНБ гэдэг нь хөрөнгө санхүү хөдөлмөр (боловсон хүчин, тэдгээрийн үр чадвар)-ийн бүхий л төрлийн нөөцийг зохих хэмжээнд бүрдүүлсэн "хар хайрцаг" гэж үзэн тэдгээр нөөцийн ашиглалтын үр дүнг нэгтгэн цогц байдлаар авч үзэхийг санал болгодог. Энэ нөхцөлд ААНБ-ын тогтвортой байдал нь тухайн байгууллага нэгжийн тогтвортой хөгжил, санхүү-эдийн засгийн үзүүлэлтийн эерэг өөрчлөлт, тэнцвэр харьцаагаар тодорхойлогдоно.

Ийнхүү тогтвортой байдлыг динамик загвараар тодорхойлохын тулд сонгон авсан үзүүлэлтийн өөрчлөлт, хөрөнгө нөөцийн ашиглалтын байдлыг тодорхой түвшингээр (сайн, дунд, муу, эсвэл хэвийн, хэвийн бус, хүндрэлтэй г.м) зааглан үнэлэх хэрэгтэй болдог.

Үйлдвэрийн газрын эдийн засгийн тогтвортой байдал бол байгууллагын чадавхи, гадаад орчны сөрөг үйлдэлийг дааж зохицон амьдрах, тасралтгүй хөгжлийн төлөв байдлын илэрхийлэл юм.

Үзүүлэлт нэг бүрийн өөрчлөлтийн түвшингээр ААНБ-ын болон салбарын рейтинг тодорхойлох, нэгдсэн (иж бүрэн) үнэлгээ дүгнэлт өгөхийн тулд өөрчлөлтийн чиг хандлага, нөлөөллийг эерэг болон сөрөг байдал, үзүүлэлтүүдийн харилцан холбоо хамаарал, бизнесийн ажиллагааны үр дүнг бодитой илэрхийлэх чадвараар нь бүлэглэсэн үзүүлэлтийн системийг зөв бүрдүүлэх (сонгон авах) явдал нэн чухал байдаг. Үүнтэй холбогдуулан тэмдэглэхэд бизнесийн тэргүүний (ТОР) нэгжүүдийг шалгаруулах, салбаруудын болон бүс нутгийн эдийн засгийн өсөлт, аюулгүй байдлын гэхчилэн олон арван индекс, нэгдсэн үнэлгээний хэмжүүрийг тооцоолдог боллоо. Энд холбогдох үзүүлэлтийн системээ зөв сонгох, иж бүрэн үнэлгээний утгыг бодитой тодорхойлоход анхаарах шаардлага байгаа юм.

Үйлдвэрийн газрын тогтвортой байдлыг түвшингээр нь максимал ба минимал гэж ангилах бөгөөд максимал тогтвортой байдал гэдэг нь тухайн байгууллага гадаад орчны сөрөг үйлдлийн эерэг сөрөн зогсох чадварын хамгийн дээд боломж нөхцөлийг бүрдүүлсэн байдал юм. Минимал буюу дундаж тогтвортой байдал нь гадаад орчны сөрөг үйлдлийн эерэг үйлчлэх чадвар боломж сул, удирдлагын хувьд бүрэн бие даасан боловч үйл ажиллагаа нь ихэвчлэн гадаад орчны нөлөөллөөр тодорхойлогдох буюу гаднаас хамаарал ихтэй байдал юм. Бидний өнөөгийн зорилт бол эдийн засгийн салбарууд болон ААНБ-ын ядахдаа минимал тогтвортой байдлыг хангах, улмаар максимал түвшин рүү цуцалтгүй тэмүүлэх явдал байх учиртай.

Тогтвортой байдалд нөлөөлөх хүчин зүйлсийг дотоодын болон гадны гэж ангилах бөгөөд

Дотоодын хүчин зүйлсэд: үйлдвэрлэлийн болон байгууллагын удирдлагын зохион байгуулалтын түвшин, хөдөлмөр, материал болон хөрөнгийн бүтээмж, эргэц үйлдвэрлэлийн төрх байдал зэргийг хамруулан үздэг.

Гадны хүчин зүйлсэд: Хэрэглэгчдийн төлбөрийн чадвар, өрсөлдөөний түвшин, хууль эрх зүйн болон эдийн засгийн орчин, нөөц хангамжийн болон санхүүгийн үйлчилгээний боломж зэргийг авч үздэг. Хүчин зүйлс нь үйл ажиллагаанд шууд ба шууд бус замаар нөлөөлж болно. Шууд нөлөөлөх хүчин зүйлд мэдээллийн хангамж, эрх зүйн орчин, төрөөс явуулж буй хөрөнгө оруулалтын бодлого, инфляци, байгаль цаг уур, байршилын нөлөөлөл зэрэг хамаарна. Харин шууд бусаар нөлөөлөх хүчин зүйл нь улс төрийн болон эдийн засгийн байдал, шинжлэх ухаан техникийн бодлого, дэлхийн зах зээлийн байдал, хүн амын нийгмийн төлөв байдал зэрэг болно. Эдгээр хүчин зүйлүүдийг урьдчилан танин мэдэх, зөв дохиолол авах, оношлогоог оночтой хийж алсын хараатай удирдахын тулд тэдгээрийг дотоодын болон гадаад орчны болон хамаарах эсэхээр нь, эсвэл субъектээр нь ангилахад гол нь биш хамгийн чухал нь удирдлагын байр сууринаас буюу ач холбогдлоор нь дараахь 4 бүлэгт ангилан авч үзэх боломжтой.

1. Зохицуулах хүчин зүйл: Зах зээлд үйлчилж буй үйлдвэрлэлийн нөөц
2. Уялдуулах (маркетинг, хангамж, худалдаа, зохион байгуулалт гэх мэт) хүчин зүйл: өрсөлдөөний төвшин, шинжлэх ухаан-техникийн дэвшил, норм норматив стандарт, худалдан авагчдын эрэлт, сонирхол
3. Урьдчилан тооцоолох хүчин зүйл: Эрэлтийн өөрчлөлт, шинэ өрсөлдөгчид бий болох, шинэ бүтээгдэхүүн борлуулах, макро түвшин өөрчлөгдөх
4. Урьдчилан тооцоолох боломжгүй хүчин зүйл: Онцгой тохиолдлын шинжтэй үзэгдэл (цаг агаар, техник ийн осол болон нийгмийн үзэгдэл, зэрэг давагдахгүй хүчин зүйлүүд)

Зарим судлаачид хүчин зүйлсийг дотоодын болон гадаад буюу байгууллагын үйл ажиллагаанаас хамаарах байдлаар нь ангилахыг чухалчлан агуулгаар нь (эдийн засгийн, зах зээлийн г.м) авч үзэх, дотоод хүчин зүйлсийг үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд үйлчлэх хүрээгээр ангилах нь зохистой гэсэн байр суурийг илэрхийлэх нь бий.

Тогтвортой байдлыг бүрдүүлэгч элементүүдийг дараах байдлаар тодорхойлж болно.

1. Зах зээлийн нөхцөл байдал. Өөрийн бүтээгдэхүүн үйлчилгээний борлуулалтын суваг үнэлэмжийг дээшлүүлэх, эрэлтийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн маркетингийн үйл ажиллагааны үр ашиг буюу **зах зээлийн тогтвортой байдал**

2. Үйлдвэрлэл борлуулалтын оновчтой хэмжээ, үйлдвэрлэлийн удирдлага, техник зохион байгуулалтын төвшин, гэрээний үүргийн биелэлт, хөрөнгийг зөв байршуулах зэрэг үзүүлэлтээр тодорхойлогдох **үйлдвэрлэлийн тогтвортой байдал**
3. Хөрөнгө капиталын тэнцвэрт харьцаа, тэдгээрийн оновчтой байршуулах, борлуулалтыг идэвхжүүлэх нөхцөл боломж, тэрчлэн санхүүгийн үүрэг хариуцлагыг бэхжүүлэх зэрэг хүчин зүйлээс үүдэн хэрэгждэг **санхүүгийн тогтвортой байдал**
4. Улс төр, эдийн засгийн бодлого, болон эрх зүйн зохицуулалтаар тодорхойлогддог **нийгэм-улс төрийн тогтвортой байдал** зэрэг болно.

Тогтвортой байдлын шинж төлөвүүд, түүнийг хангах арга механизм, нөлөөлөх хүчин зүйлүүдийг сайтар танин мэдэх, тэр хэмжээгээр гүйцэтгэлийн тоо мэдээллийг тал бүрээс нь судлан боловсруулалт хийж үнэлгээ дүгнэлт өгөх, улмаар удирдлагын аливаа шийдвэрийг гаргахдаа судалгааны дүгнэлт саналыг бүтээлчээр ашиглах ур чадварыг дээшлүүлэх, ийм хэрэглээнд суралцах нь эдийн засгийн өсөлт, бизнесийн тогтвортой байдлыг хангахад нэн чухал болж байна.

Хоёр. Бизнесийн салбаруудын зарим харьцуулсан судалгаа, дүгнэлт

Эдийн засгийн тогтворжилт, тэр дундаа бизнесийн салбаруудын санхүүгийн тогтвортой байдал гэдэг нь салбар болон ААНБ-ын хэмжээнд бизнесийн болзошгүй эрсдлийг даван туулж, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах явдал гэж болно.

2007 оны урьдчилсан гүйцэтгэлээр манай улсын эдийн засгийн бодит өсөлт 9.9 хувь, нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ 1,472.2 ам.доллар болж, 2006 оны түвшингээс 20.5 хувиар өссөн бөгөөд 2008 онд эдийн засгийн бодит өсөлтийг 10.1 хувьд хүргэхээр төлөвлөн ажиллаж байгаа билээ. Эдийн засгийн өсөлтийг үндсэн салбараар авч үзвэл

Хүснэгт 1

ДНБ-ний өсөлт (хувиар)

Салбарууд	2003	2004	2005	2006	2007*	2008**
Хөдөө аж ахуй	4.9	17.7	9.6	7.5	10.0	5.0
Үйлдвэрлэл	4.8	15.0	1.2	7.0	7.9	11.5
Үйлчилгээ	6.1	6.3	8.3	10.0	11.1	11.5
Нийт	5.6	10.7	7.0	8.6	9.9	10.1

* - ХБГ, ** - төсөөлөл

Эх сурвалж: Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2008 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл.

2008 он гарсаар дэлхий нийтийн хэмжээгээр нефть шатахууны үнэ өсч, хүнсний зарим бүтээгдэхүүн (гурил, улаанбуудай, цагаан будаа г.м.) хомсдол үүссэний нөлөөгөөр манай импортын цөөнгүй нэрийн бүтээгдэхүүний хэрэглээний үнийн индекс огцом өсч инфляци оны эхнээс 20 орчим хувь болоод байгаа нь салбаруудын эдийн засгийн өсөлтөнд сөргөөр нөлөөлж болзошгүй төлөвтэй байна.

Бид бизнесийн байгууллагын санхүүгийн чадавхийг тодорхойлох нэгэн сэдэвт судалгаа²¹ болон Сангийн яамны нэгтгэсэн 2003-2006 оны “Санхүүгийн тайлангийн нэгтгэл”-ийн тоон мэдээллийг ашиглан манай улсын ААНБ-уудын санхүүгийн тогтворжилтыг эдийн засгийн үндсэн салбаруудаар тооцоолж өмнөх 5 жилийн дундажтай харьцуулан дүгнэлт өгөхийг хичээлээ.

Энэ зорилгоор бизнесийн байгууллага болон салбаруудын эдийн засгийн өсөлт болон санхүүгийн тогтвортой байдлыг:

1. Хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийн өсөлт, тэдгээрийн бүрэлдэхүүний тэнцвэрт байдал.
2. Бизнесийн байгууллагын санхүүгийн тогтворжилт, төлбөрийн чадвар.
3. Орлого, үр дүн (ашиг)-ийн жигд өсөлт, бизнест оруулсан хөрөнгийн ашиглалт, өгөөж гэсэн багц үзүүлэлтээр тооцоолж, Хөдөө аж ахуй, Уул уурхайн олборлох үйлдвэрлэл, Боловсруулах үйлдвэр, Барилгын зэрэг бодит салбараар зэрэгцүүлж үзүүлэв.

2. Хөрөнгө, санхүүжилтийн өсөлт, тэнцвэржилт

Эдийн засгийн бодит өсөлт, бизнесийн цар хүрээ нэмэгдэхийн хэрээр санхүүжилтийн хэрэгцээ өсөх нь зүйн хэрэг. Санхүүжилтийн нэмэгдэл хэрэгцээг дан ганц өөрийн хөрөнгөөр хангах боломжгүй учраас гадаад санхүүжилтийн хувийн жин нэмэгдэж, активийн бүтэц удирдлага сайжрах хандлага тайлангийн нэгтгэлээс ажиглагдаж байна.

Тухайлбал, ААНБ-ын нийлбэр дүнгээр байгууллагын нийт хөрөнгө 2006 онд 7,718.9 тэр бум төгрөгт хүрч 2003 оноос 2.3 дахин, эзэмшигчийн өмч 3,219.2 тэр бум төгрөг болж, 2003 оноос 2 дахин өссөн бөгөөд эргэлтийн хөрөнгийн хувийн жин 1996-2000 онд дунджаар 27.0 хувь байсан нь 2003-2006 онд 39.2 хувь болж нэмэгдсэн төдийгүй 2006 оны гүйцэтгэл 40.8 хувь болж хэлбэрэлтгүй өсч хөрөнгийн хөрвөх чадвар, маневрлах боломж сайжирсан байна.

²¹ Б.Сайнжаргал, Ж.Бат-Өлзий “Бизнесийн байгууллагын санхүүгийн чадавхийн судалгаа” (1996-2000 он)

Хүснэгт 2

ААНБ-ын хөрөнгө, санхүүжилтийн бүтэц (хувиар)

Үзүүлэлтүүд	2003-2006 оны дундаж	Сүүлийн 4 жилд				1996-2000 оны дундаж
		2006	2005	2004	2003	
1 Хөрөнгийн бүрэлдэхүүн						
Эргэлтийн хөрөнгө	39.2	40.8	39.7	39.3	34.6	27.0
Эргэлтийн бус хөрөнгө	60.8	59.2	60.3	60.7	65.4	73.0
Дүн	100	100	100	100	100	100
2 Санхүүжилтийн бүрэлдэхүүн						
Өр төлбөр	57.7	58.3	56.4	56.3	53.9	32.0
Эзэмшигчийн өмч	42.3	41.7	43.6	43.6	46.1	68.0
Дүн	100	100	100	100	100	100

Эх сурвалж: Тайлангийн нэгтгэлд хийсэн судалгаа, тооцоогоор.

1996-2000 онд нийт хөрөнгийн 68.0 хувийг өөрийн хөрөнгө (эзэмшигчийн өмч)-өөр санхүүжүүлж байсан бол 2006 онд 41.7 хувь болон багасаж, гадаад эх үүсвэрийн оролцоо бараг 60 хувьд хүрсэнийг Хүснэгт 2-оос харж болох юм.

Нийт санхүүжилтэнд зээл төлбөрийн оролцоо нэмэгдэн, өрийн харьцаа 2006 онд $1.40 > 1$ болон өсч байгаатай холбогдон авсан зээлээ хугацаандаа эрүүлж төлөх бизнесийн тогтвортой орчныг бүрдүүлэх санхүүгийн хариуцлага нэмэгдэж байна.

Байгууллагын эрхлэж буй үйл ажиллагааны онцлогоос хамааралтайгаар хөрөнгийн болоод санхүүжилтийн бүтэц нь эдийн засгийн салбаруудаар мэдэгдэж ялгаатай байх нь зүйн хэрэг юм. Сүүлийн 4 жилийн дунджаар тооцсон зэрэгцүүлсэн судалгаанаас үзвэл эргэлтийн хөрөнгийн хувийн жин Барилгын салбарт 56.5 хувь байгаа нь бусад салбаруудаас хамгийн өндөр, харин эргэлтийн бус хөрөнгийн хувийн жин Эрчим хүчний салбарт хамгийн өндөр буюу 80.6 хувьтай гарч байна.

Санхүүжилтийн бүтцийн тухайд Барилгын салбарт нийт хөрөнгийн 62.8 хувийг зээл болон бусад өр төлбөрөөр, харин Хөдөө аж ахуйн салбарт 54.8 хувийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн нь тус бүрдээ хамгийн өндөр үзүүлэлт болж байна.

Бизнесийн тогтвортой ажиллагаанд эргэлтийн хөрөнгийн хангамж, түүнийг санхүүжүүлэх эх үүсвэрийн хүрэлцэхүйц байдал онцгой үүрэгтэй. Энэ үүднээс авч үзэхэд 2006 онд Боловсруулах үйлдвэр болон барилгын салбарт өөрийн эргэлтийн хөрөнгө 123.7 - 7.4 тэрбум төгрөгөөр, сүүлийн 4 жилийн дунджаар тооцоход барилга болон ХАА-н салбарт 19.2 - 2.2 тэрбум төгрөгөөр тус бүр дутагдаж байгааг Хүснэгт 3-аар тооцож гаргасан болно.

2. Санхүүгийн тогтвортой байдлын харьцаанууд

Бизнесийн байгууллагын, тэр дундаа эдийн засгийн бодит салбаруудын санхүүгийн чадавхийн өсөлтөнд дүгнэлт өгөх зорилгоор нэн холбогдолтой гэж болох 4 бүлэг үзүүлэлтийг салбар тус бүрээр 2003-2006 оноор тооцоолж өмнөх 5 жилийн дундажтай нь зэрэгцүүлж үзүүлэв (Хүснэгт).


2.1. Санхүүгийн тогтворжилт. Бизнесийн санхүүгийн орчин сайжран, эдийн засгийн өсөлт тогтворжихын хэрээр ААНБ-ын борлуулалтын орлого (оны үнээр) 2003-2006 онуудад тогтвортой нэмэгдэн 2006 оны гүйцэтгэл 5,702.7 тэрбум төгрөгт хүрснийг график 1-ээр үзүүлэв.

Борлуулалтын орлогын жил тутмын цэвэр өсөлт 32.4-41.8 хувь болж өсөлт нь улам бүр эрчимжсэн төдийгүй бизнесийн тасралтгүй ажиллагааг хангахад зориулагдсан ажлын капиталын дүн 2006 онд 612.1 тэрбум төгрөг болж ойролцоогоор 40 хоногийн гүйлгээг хангахуйц хэмжээнд хүрчээ.

Тэгэхдээ 2006 оны байдлаар өөрийн эргэлтийн хөрөнгө Боловсруулах үйлдвэрт 123.7 тэрбум, Барилгад 7.4 тэрбум төгрөгөөр дутагдалтай гэсэн тооцоо гарч байгаа (Хүснэгт 3) нь санхүүгийн тогтворжилт бодит салбаруудад тэр бүр хангагдаж чадаагүй байгаагийн илэрхийлэл гэж болно.

График 1

Борлуулалтын орлого (тэрбум төгрөг, өсөлт хувиар)



ААНБ-ын өөрийн санхүүжилт (бие даалт)-ын коэффициент жил дараалан буурсаар 2006 онд 0.417 болж, энэ хэмжээгээр өрийн харьцаа нэмэгдэж байгаа нь нэг талаар бизнесийн цар хүрээний өсөлттэй уялдан хөрөнгө оруулалтын нэмэлт санхүүжилтийг гол төлөв зээл төлбөр зэрэг гадаад эх үүсвэрээр нөхсөн нь зүйн хэрэг боловч бизнесийн ашиг, хуримтлал тогтвортой нэмэгдэж өөрийн санхүүжилтийн өсөлтийг хангаж чадахгүй байна гэсэн дүгнэлтэнд хүргэж байна. Хуримтлагдсан ашгийн цэвэр өсөлтөөр тооцоход эдийн засгийн өсөлтийн тогтворжилт ААНБ-ын дүнгээр:

	2006	2005	2004
Тогтворжилтын коэффициент	0.087	0.103	0.069

2004 онд 6.9 хувь, 2005 онд 10.3 хувь гэхчилэн ерөнхийдөө нэмэгдэх хандлагатай боловч цэвэр өсөлтийн хэмжээ бага, бас тэгээд тогтвортой бус байгаа нь дээрх дүгнэлтийг зарим талаар баталж байгаа юм. Өөрийн санхүүжилт болон өрийн харьцааг салбаруудаар болон ААНБ-ын дүнгээр авч үзэхэд:

Хүснэгт 3

Эдийн засгийн бодит салбаруудын санхүүгийн тогтворжилт

№	Салбарууд	2006 оны гүйцэтгэлээр			2003-2006 оны дундаж		
		Бие даалт (ӨК/НХ)	Ажлын капитал (тэрбум)	Өрийн харьцаа (ГК/ӨК)	Бие даалт (ӨК/НХ)	Ажлын капитал (тэрбум)	Өрийн харьцаа (ГК/ӨК)
1	Хөдөө аж ахуй	0.603	1.9	0.66	0.548	(2.2)	0.82
2	Уул уурхай, олборлох	0.393	364.1	1.54	0.429	220.8	1.33
3	Боловсруулах үйлдвэр	0.273	(123.7)	2.66	0.444	(19.2)	1.25
4	Барилга	0.346	(7.4)	1.89	0.372	2.4	1.69
5	Эрчим хүч	0.377	10.1	1.65	0.418	5.5	1.39
	ААНБ-ын дүнгээр	0.417	612.1	1.40	0.423	467.5	1.09


ХАА-н салбарт өөрийн санхүүжилт 2006 онд 60.3 хувь, 2003-2006 оны дундаж нь 54.8 хувь байгаа (зээлийн олдоц бага)-ийн дүнд өрийн харьцаа бага, харин бусад салбаруудад зээлийн санхүүжилт зонхилох нөлөөтэй гэж гарч байна.

2.2. Төлбөрийн чадвар бол ААНБ-аас харилцагчдын өмнө хүлээх санхүүгийн үүрэг, хариуцлагын гол шалгуур юм.

Тайлангийн нэгтгэлийн (ААНБ) дүнгээр тооцоход эргэлтийн хөрөнгийн харьцаа 1996-2000 оны дунджаар 1.92 байсан нь 2006 онд 1.24, сүүлийн 4 жилийн дундаж нь 1.28 болж буурах хандлагатай байгааг дараах График 2-оос харж болно.

График 2

Төлбөрийн чадварын харьцаа



Харин төлбөрийн ойрын боломж (түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа) сүүлийн жилүүдэд харьцангуй тогтвортой 0.70-0.72 байгаа хэдий ч дундаж жишгээс тус бүрдээ 36.2-25.6 хувиар доогуур байгаа нь манай бизнесийн байгууллагуудын төлбөрийн чадвар төдийлөн сайн бус байгааг илэрхийлж байна.

Гадаад санхүүжилтэнд урт хугацаат зээл төлбөрийн оролцоо нэмэгдэж, тэр нь 1996-2000 онд нийт санхүүжилтийн 18.0 хувь байсан бол 2003-2006 онд 25.9 хувь болж өссөн нь төлбөрийн өнөөгийн боломжинд эерэгээр нөлөөж байгаа хэдий ч цаашдаа дарамт үүсгэж болзошгүй гэдгийг анхаарвал зохино.

Төлбөрийн чадварыг эдийн засгийн салбаруудаар тооцож үзэхэд:

Хүснэгт 4

Төлбөрийн чадварын харьцаа


	Эргэлтийн хөрөнгийн					Түргэн хөрвөх хөрөнгийн				
	2003-2006	2006	2005	2004	2003	2003-2006	2006	2005	2004	2003
Хөдөө аж ахуй	0.89	1.09	0.83	0.86	0.77	0.41	0.53	0.36	0.39	0.34
Уул уурхай, олборлолт	2.33	2.31	2.59	2.35	2.00	1.12	1.32	1.21	0.92	0.71
Боловсруулах үйлдвэр	0.91	0.67	1.05	1.11	1.15	0.47	0.38	0.50	0.56	0.58
Барилга	1.03	0.93	0.97	1.22	1.19	0.46	0.45	0.45	0.47	0.50
Эрчим хүч	1.07	1.14	1.05	1.06	1.03	0.68	0.70	0.64	0.64	0.76

Эргэлтийн хөрөнгийн харьцаа Уул уурхайн салбарт харьцангуй дээгүүр бөгөөд нэмэгдэх хандлагатай, Эрчим хүч болон Барилгын салбарт дунд зэрэг, Боловсруулах аж үйлдвэр болон ХАА-н салбарт сул буюу эргэлтийн хөрөнгө дутагдалтай, түүнийгээ бүхэлд нь богино хугацаат өр, зээлээр санхүүжүүлж (ЭХ<БХӨ) байгаа дүр зураг харагдаж байна. Төлбөрийн ойрын боломжийн хувьд Уул уурхайн салбараас бусад нь авлагаа бүрэн цуглуулаад ч хүлээгдэж байгаа өрийн 40-60 хувийг л барагдуулахаар буюу төлбөрийн чадвар сул байгааг харж болно.

2.3. Бизнес-оргуулсан хөрөнгийн ашиглалтыг сайжруулах явдал нь эдийн засгийн өсөлтийн үндсэн эх сурвалж байдаг. Борлуулалтын орлогоор тооцсон нийт хөрөнгийн ашиглалт (ачаалал) ААНБ-ын дүнгээр 1996-2000 онд 48 мөнгө байсан нь хэлбэрэлтгүй нэмэгдсээр 2006 онд 73.9 мөнгө, 2003-2006 оны дундаж нь 67.1 мөнгө болж бараг 40 хувиар өссөн (Хүснэгт 6), харин эргэлтийн хөрөнгийн эргэцийн хугацаа өмнөх 5 жилийн дундажаас удааширсаныг дараах График 3-р харуулав.

График 3

Хөрөнгийн эргэц (хоногоор)



Хөрөнгийн эргэцийн хугацаа 2003 ба 2004 онд удааширч харин 2005 оноос эхлэн тогтвортой буурах хандлагтай болсны дүнд 2006 онд өмнөх 5 жил (1996-2000 оны) түвшинд ойртон 162 хоног болсон бөгөөд нийт салбаруудын үйлдвэрлэлийн мөчлөгийн хугацаа 177 хоног буюу бараг хагас жилээр хэмжигдэж байна. Зээлээрх худалдан авалт болон бусад богино хугацаат өглөгөөр тооцсон өглөг барагдуулалтын хугацаа 2003-2006 оны дунджаар 121 хоног буюу 4 сар орчим байгаагаас үзвэл ААНБ-ын дүнгээр үйлдвэрлэлийн мөчлөгийн 68.4 хувийг зээл, төлбөрөөр санхүүжүүлж, үлдэх 2 сарын авлага ба нөөцийг өөрийн хөрөнгөөр нөхдөг юм байна.


Тайлангийн нэгтгэлийн 2006 оны дүнгээр ААНБ-ын дансны өглөг нь дансны авлагаас 31.2 хувиар буюу 320.2 тэрбум төгрөгөөр илүү байгаа нь харилцагч, түншүүдийн өр төлбөрийг хугацаанд нь төлж барагдуулдаг бизнесийн итгэлтэй харилцагчийн соёл төлөвшөөгүй, тийм санхүүгийн боломж ч сул байгаагийн илэрхийлэл гэж болно.

Салбаруудаар авч үзвэл үйлдвэрлэлийн мөчлөгийн хугацаа Барилгын болон ХАА-н салбарт 270-275 хоног, Боловсруулах үйлвэр болон уул уурхайд 240-250 хоног гэж гарсан бөгөөд салбаруудын үйлдвэрлэлийн болон санхүүгийн мөчлөгийн хугацаанд үйл ажиллагааны улирлын шинж байдал, борлуулалтын сувгууд, харилцагчдын төлбөрийн чадвар зэрэг бодит хүчин зүйлүүдээс гадна санхүүгийн удирдлагын нөлөөлөл ч байдаг нь харагдаж байгаа юм.

2.4. Хөрөнгө, капиталын өгөөж, ашигт ажиллагаа. ААНБ-ын үйл ажиллагааны бизнесийн үр дүн нь ашгийн өсөлт, хөрөнгө оруулалтын өгөөжөөр хэмжигддэг нь нийтлэг жишиг билээ. Судалгаанд хамрагдсан ААНБ-ын дүнгээр хөрөнгийн нэгжид ноогдох ашиг 1996-2000 онд 2.5 орчим хувь байсан нь жил тутам нэмэгдсээр 2006 онд 6.71 хувьд хүрч сүүлийн 4 жилийн дундаж 4.2 хувь болсныг График 4-өөр харуулав.

График 4

Хөрөнгийн болон борлуулалтын өгөөж (хувиар)



Эзэмшигчдийн өмчийн өгөөж 2006 онд 16.1 хувь болж 2003 оныхоос 5 дахин, борлуулалтын ашгийн түвшин 9.1 хувь болж 3.5 дахин нэмэгдсэн нь ААНБ-ын бизнесийн үр өгөөж тогтвортой дээшилж байгаагийн илэрхийлэл бөгөөд энэ өсөлт нь хөрөнгийн зах зээл сэргэхэд эергээр нөлөөлж, нэг бус арилжааны банк, томоохон компаниуд хувьцаат компаний хэлбэрт шилжих, хувьцаа болон өрийн бичиг гарган хөрөнгийн зах зээлээс санхүүжилт авах явдал түгээмэл боллоо.

ААНБ-ын татварын өмнөх ашиг тайлангийн нэгтгэлээр 2006 онд 518.0 тэрбум төгрөгт хүрч сүүлийн 4 жилд 10 дахин өссөнөөр төсвийн татварын орлого төдийгүй, эзэмшигчдэд олгох ногдол ашгийн боломж нэмэгдэж байна. Эдгээрийн үр дүнд Монголын хөрөнгийн зах зээл сэргэн, хөрөнгийн бирж (МХБ)-ийн арилжааны дүн 2005-2006 онд 3 дахин нэмэгдсэн төдийгүй зөвхөн 2008 оны эхний улирлад 9.2 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэний дүнд компаниудын зах зээлийн үнэлэмж оны эхнээс 24.2 хувиар өсөж 890.0 тэрбум төгрөгт хүрснийг МХБ-ээс мэдээлсэн байна²².

Салбаруудаар аваад үзвэл өөрийн хөрөнгийн өгөөж хамгийн өндөртэй нь Уул уурхай, олборлох үйлдвэр байгаа бөгөөд өгөөж нь жил дараалан нэмэгдсээр 2006 онд 49.8 хувь, сүүлийн 4 жилийн дундаж нь 36.8 хувь болсон байна.

Гэтэл Боловсруулах үйлдвэр 2003-2006 оны дунджаар 14.1 хувь, барилга болон ХАА-н салбар тус бүр 3.2-3.5 хувь, Эрчим хүчний салбар 1.4 хувийн алдагдалтай гэж гарч байгааг дараах тооцооноос харж болно.

²² "Өнөөдөр сонин" 2008 оны V сарын 9. №108 (3371)

Хүснэгт 5

Хөрөнгийн өгөөж, борлуулалтын ашиг (хувиар)

	Өөрийн хөрөнгийн өгөөж					Борлуулалтын ашиг				
	2003-2006	2006	2005	2004	2003	2003-2006	2006	2005	2004	2003
Хөдөө аж ахуй	-3.51	0.00	-8.16	0.35	-9.19	-4.47	0.00	-7.96	0.48	-12.77
Уул уурхай, олборлолт	36.80	49.84	32.0	33.14	12.59	25.26	30.31	23.72	24.80	9.63
Боловсруулах үйлдвэр	-14.06	-4.42	-1.83	-43.51	-2.59	-11.15	-1.85	-1.55	-40.69	-3.77
Барилга	-3.23	-10.60	1.30	0.25	-0.80	-1.18	-3.92	0.71	0.23	-0.71
Эрчим хүч	-1.42	0.50	-0.04	-5.54	-1.15	-1.10	0.38	-0.03	-4.37	-1.06

Эх сурвалж: Тайлангийн нэгтгэлээс хийсэн тооцоогоор.

Борлуулалтын ашгийн түвшингийн хувьд мөн л адилхан дүр зураг харагдаж байгаа төдийгүй, алдагдал төдийлөн буурахгүй, он бүрээр нилээд хэлбэлзэлтэй, хачирхалтай нь нилээд ашигтай гэгддэг Бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарын борлуулалт 2003-2006 оны дунджаар 0.8 хувийн, зочид буудал, зоогийн газрынх 15 хувийн алдагдалтай гэж гарсан нь эргэлзээ төрүүлж байгаа юм. Эндээс ААНБ-ын орлого үр дүнгийн тайлагналын үнэн зөв байдалд анхаарахгүй бол бодит мэдээлэл гаргах боломжгүй болж, нэгтгэлийн ач холбогдол алдагдахад хүрч байна. 2007 онд хийгдсэн татварын шинэчлэл, өршөөлийн арга хэмжээний нөлөөгөөр 2007-2008 оны тайлангууд эрх биш бодитой гарах байх гэсэн найдлага байгаа юм.

Ийнхүү ашгийн түвшинд нөлөөлөх хүчин зүйл, нийт ашгийн бодлого, зохицуулалт үйлдвэрийн салбарууд болон ААНБ-ын хэлбэрүүдээр харилцан адилгүй байгаа нь бизнесийн байгууллагын ашигт ажиллагааны ерөнхий түвшинд нөлөөлж байна.

Өнгөрсөн 10 орчим жилийн зэрэгцүүлсэн судалгаанаас ерөнхийд нь дүгнэвэл улс орны бизнесийн болон эдийн засгийн орчин сайжрахын хэрээр ААНБ-уудын санхүүгийн тогтворжилт, төлбөрийн чадварын харьцаанууд сайжирсан хэдий ч орлого хуримтлалтын өсөлт нь хөрөнгө оруулалтын өсөлтийг тэр бүр гүйцэж чадахгүй байгаагийн улмаас хөрөнгийн ашиглалт (бүтээмж), оруулсан хөрөнгийн өгөөж дорвитой нэмэгдэхгүй, олонхи салбарууд алдагдалтай ажилласаар байна. Алдагдлын шалгаан нь салбарын болоод зохион байгуулалтын хүчин зүйлүүдээс голдуу хамааралтай гэж болох авч санхүүгийн хүчин зүйлийн нөлөөлөл багагүй байгааг судалгаа илтгэж байна.

ААНБ-уудыг, тэр дундаа бизнесийн байгууллагуудын санхүүгийн чадавхи, тогтворжилтыг улс орны хэмжээнд төдийгүй бүс нутаг, үйл ажиллагааны салбарууд, зохион байгуулалтын хэлбэрээр ангилан судалж тухайн нэгжийн хүрсэн түвшин, байр суурийг тодорхойлох нь нэг талаас өөрийн эрхлэж буй бизнесийг бодитой үнэлж, хэтийн зорилго чиглэлээ тодорхойлоход тустайгаас гадна хөрөнгө оруулалтын болон зээлийн

эрсдлээ зөв тооцоолж харилцагчаа сонгох, эцэст нь тухайн бизнесийн үр ашигт шууд болон дам нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийг тодорхойлоход судалгааны ач холбогдол нь оршино.

Цаашдаа санхүүгийн тайлагналын үнэн зөв, шуурхай байдлыг хангах, салбар тус бүрээр тайлангийн нэгтгэлийн мэдээллийн сан бүрдүүлж, түүнийгээ хөрөнгө оруулагчид болон бизнес эрхлэгчидэд нээлттэй болгох, нэгтгэлд хийсэн судалгаа дүгнэлтийг хэвлэлээр нийтэлж бизнесийн болоод судалгааны эргэлтэнд оруулах шаардлага тавигдаж байна.

Хүснэгт 6

ААНБ-уудын дүнгээр тооцсон Санхүүгийн үндсэн үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	2003-2006 оны дундаж	Сүүлийн 4 жилд				1996-2000 оны дундаж
		2006	2005	2004	2003	
1 Санхүүгийн тогтворжилт						
Бие даалтын коэффициент (ӨК/НХ)	0.423	0.417	0.436	0.439	0.461	0.674
Өөрийн эргэлтийн хөрөнгө (тэрбум төгрөг)	467.5	612.1	504.4	468.6	285.2	
Өрийн харьцаа (ГК/ӨК)	1,109	1.40	1.292	1.279	1.16	0.483
2 Төлбөрийн чадвар						
Нөхөлтийн коэффициент (ЭХ/БХӨ)	1,276	1,241	1,270	1,319	1,318	1.92
Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа	0.715	0.721	0.721	0.711	0.693	0.86
3 Хөрөнгийн ашиглалт, эргэц						
Нийт хөрөнгийн ачаалал	0.671	0.739	0.674	0.614	0.595	0.48
Авлагын эргэц (хоногоор)	81	75	82	90	79	75
Нөөцийн эргэц (хоногоор)	96	87	92	114	101	94
Өглөгийн эргэц (хоногоор)	121	108	137	141	120	
Үйлдвэрлэлийн мөчлөг	177	162	174	204	180	169
Санхүүгийн мөчлөг	56	54	37	63	60	
4 Хөрөнгийн өгөөж						
Нийт хөрөнгийн өгөөж (ЦА/НХ)	4.15	6.71	4.41	1.65	1.52	2.48
Өөрийн капиталын өгөөж (ЦА/ӨК)	9.56	16.09	10.10	3.76	3.30	2.52
Борлуулалтын ашигт ажиллагаа (ЦА/БО)	6.18	9.08	6.54	2.68	2.56	4.54

Эх сурвалж: Тайлангийн нэгтгэлээс хийсэн тооцоогоор.